



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БҮРД СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 12/06

Онгон

Хоршоог хөгжүүлэх сангийн тэргүүлэх
чиглэл батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 сарын 13-ний өдрийн А/361 дугаар тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


- 1.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлээр дэмжих орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.
- 2.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 09/04 тогтоолын хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.ДЭЖИД

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 сарын 11-ний өдрийн 18-д
тогтоолын хавсралт



ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Нэг. Хоршоо

Хоёр. Аж ахуй нэгж

Гурав. Газар тариалангийн чиглэлээр

1. Хүлэмж хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлэх
2. Мод үржүүлэг, жимс жимсгэнийн мод бут тариалах
3. Хүнсний ногоо тарих, даршлах нөөшлөх
4. Зоорь барих, засварлах
5. Малын тэжээлийн тариалалт

Дөрөв. ЖДҮ-ийн чиглэлээр

1. Мал нядалгааны цэг, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн /өлөнгэдэс, яс, эвэр, туурай, өөх, тос, сэвс/ боловсруулах цех
2. Сүү, цагаан идээ боловсруулах цех
3. Талх, нарийн боовны үйлдвэрлэл
4. Туслах аж ахуй /гахай, тахиа/
5. Сур, арьс ширээр тоноглол, хэрэглэл хийх, түүхий эд боловсруулах,
6. Гэр ахуйн болон албан тасалгааны тавилга үйлдвэрлэх цех
7. Хувцас захиалга засвар, хатуу зөөлөн оёдол
8. Гар урлал /бэлэг дурсгалын зүйл/
9. Барилгын материалын үйлдвэрлэл, төмөрлөг, төмөр эдлэл
10. Авто засвар
11. Нийтийн хоол үйлдвэрлэл

_____оОо_____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БҮРД СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 9/04

Бүрд сум

Төсөл сонгон шалгаруулах хороо
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн А/361 дугаар тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.4, 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|----------------------|--|
| Хорооны дарга | -Засаг даргын Тамгын газрын дарга |
| Нарийн бичгийн дарга | -Хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүдэд | -Санхүүгийн албаны дарга |
| холбооны гишүүн/ | -Н.Түмэнжаргал /Баялаг бүтээгчдийг дэмжих |
| холбооны гишүүн/ | -Р.Гэрэлсүрэн /Баялаг бүтээгчдийг дэмжих |

2.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлээр дэмжих орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ний өдрийн 28 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  М.ДЭЖИД

C: My doc:tushaa



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 197

Онгон

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Г.Анхтөр (Санхүү албаны даргын үүрэг гүйцэтгэгч)
Гишүүд С.Урангоо (Төрийн банкны эрхлэгч)
Б.Баясгалан (Хаан банкны эдийн засагч)
Д.Балжинням (Нягтлан бодогч)
Г.Гантогоо (Газрын даамал)

2.Захирамжийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Анхтөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.МӨНХБАЯР

D:\My doc ZD (zahiramj)



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 2 өдөр

Дугаар А/108

Бүрд сум

「Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгох тухай」

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 4-ны өдрийн 153 дугаар тогтоол, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.2, 3.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох зорилгоор иргэдэд хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл 197,010,000 (нэг зуун ерэн долоон сая арван мянга) төгрөгийг олгосугай.

2. Зээл олгох иргэдийн нэрс болон мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

3. Иргэдтэй зээлийн гэрээ байгуулж зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын байрны мэдээ тайланг аймгийн ХХААЖДҮГ азарт хүргүүлж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Солонго)-д даалгасугай.

4. Дээрх зээлийг зээлдэгч бүрийн нэрийн дансанд шилжүүлж, хоршоо хөгжүүлэх сангийн орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, улирлын эхний сарын 05-ны дотор Хүнс жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж ажиллахыг Санхүү албаны дарга (Г.Анхтөрд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

М.МӨНХБАЯР

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН
ИРГЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

| № | Зээлд хамрагдсан иргэн /овог, нэр/ аж ахуй нэгж /нэр, төрөл/ | Зээлийн хэмжээ | Зориулалт | Санхуу жилт олгох хугацаа | Тайлбар |
|---|--|----------------|---|---------------------------|---|
| 1 | "Баруун боригдой" хоршоо | 50000000 | Малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, болон аравтын тогтолцоонд суурилсан малчдын жишиг газар тариалангийн хоршоог бий болгох | 12 сар | |
| 2 | "Цог-дарьт" ББН | 50000000 | Дорпер үүлдрийн хонины аж ахуй | 05 сар | Төсөл хэрэгжих хугацаа болоогүй тул санхүүжилтийг түр хугацаанд хойшлуулав. |
| 3 | Т. Рэнцэнханд | 20000000 | Мах махан бүтээгдэхүүн худалдах, худалдан авах зорь байгуулах | 12 сар | |
| 4 | Ө. Оюун-Эрдэнэ | 17010000 | Мод бут сөөг үржүүлэх, олон наст малын тэжээлийн ургамал тариалах | 12 сар | |
| 5 | Н. Цэрэндолгор | 20000000 | Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 12 сар | |
| 6 | Л. Ганбаатар | 20000000 | Эсгийний үйлдвэр байгуулах | 12 сар | |
| 7 | Д. Цээсүрэн, Г. Ичинхорлоо | 20000000 | Монгол дээл үйлдвэрлэл | 12 сар | |
| | Дүн | 197010000 | | | |



ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТ, ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ХЯНАЛТ ТАВИХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

2023 оны 05 сарын 18

Бүрд

Хяналтын ажлын зорилго: Бүрд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 сарын 27 ний өдрийн дугаар 9/05 тогтоолын дагуу байгуулагдсан хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих орон тооны бус зөвлөл нь тус сангаас 2022 онд зээл авсан иргэдийн төслийн агуулга, төсөл хэрхэн хэрэгжиж, үйл ажиллагаа эхэлсэн эсэх. Төслийн үйл ажиллагаа сум орон нутаг, иргэд, айл өрхөд үзүүлэх үр өгөөж ямар байна. Зээлийн эргэн төлөлт хугацаандаа гэрээний дагуу хийгдэж байгаа зэрэгт хяналт хийх.

Ажиллах бүрэлдэхүүн: Хяналтын зөвлөлийн дарга: С. Алтанцэцэг /ИТХ-ын төлөөлөгч

Нарийн бичиг: Г. Солонго / Хүнс, жижиг дунд үйлдвэр

хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн/

Гишүүд: Д. Балжинням / Санхүү, төрийн сангийн төлөөлөл/

Э. Тэгшбаяр / ХХААГазрын хүнс, жижиг дунд

үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн/

Г. Хишигням /Төрийн бус байгууллагын төлөөлөл/

Зохион байгуулалт:

1. Шалгарсан төслийн агуулга, барьцаа хөрөнгийн үнэлгээ, зээлийн гэрээтэй танилцах.
2. Төсөл хэрэгжүүлэгч иргэдийн тайлантай танилцах
3. Дүнгийн хурал хийх

Хугацаа: 2023 оны 05 сарын 18 -наас 2023 оны 05 сарын 23-ний өдөр хүртэл

Хамрах хүрээ: 2022 онд хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан 2 аж ахуйн нэгж, 5 иргэн

Шалгуур үзүүлэлт:

1. Бодлого төлөвлөлт, хөгжлийн баримт бичгүүдтэй уялдаж байх.
2. ИТХ-аас гаргасан үндсэн чиглэлд нийцэж байх.
3. Төсөл хэрэгжиж эхэлсэн байх.

Засаг даргын Тамгын газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/100

Бүрд сум

Захирамжийн зарим хэсгийг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн дугаар А/15 тушаал, хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журмын 7.4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгосон 2022 оны 12 сарын 22 өдрийн А/102 дугаартай захирамжийн хавсралтад байгаа 2 дугаартай "Цог-дарьт" ББН-ийн Дорпер үүлдрийн хонины аж ахуй төслийн санхүүжилтийг олгохоос татгалзсугай.

2.Тухайн төсөл хэрэгжүүлэгчид захирамжийг танилцуулж, тайлан мэдээнд тусган Хүнс, Хөдөө Аж Ахуй, Жижиг Дунд Үйлдвэрлэлийн газарт хүргэн ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Солонго)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн 1 дүгээр заалтыг мөрдлөг болгон ажиллахыг Санхүү албаны дарга (Г.Анхтөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.МӨНХБАЯР